



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус компани Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчин 69,321.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүрдэл дутуу баримтаар хийсэн, Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг зөрчин 16,387.0 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 34 дүгээр заалтын 34.3 дэх хэсэгт заасныг тус тус зөрчин 877,820.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг нийт 963,529.4 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Чимэддоржид дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:
  - 2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;
  - 2.2. Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бурдуулэх, зөрчлийг арилгах;
  - 2.3. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;
  - 2.4. Мөнгөн кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг чанд мөрдөж ажиллах, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэхгүй байх;

0000271

2.5. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг Үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчим, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллах;

2.6. Томилолтыг байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу олгох, ажлын 5 хоногийн дотор ажлын үр дүнгийн тайланг хүлээн авч, удирдлагаар дүгнүүлэн, тамга, тэмдгээр баталгаажуулсны дараа тооцоог хааж байх;

2.7. Их засвар, ТЗБАХ-ний хүрээнд хийгдэж буй ажлын тоо хэмжээ бусад зардлыг бодитой төлөвлөх, инженер техник, санхүү, бүртгэл, хангамж, төсвийн ажилтнуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах;

2.8. Байгууллагын тайлан тэнцэлд тусгагдсан авлагын насхилтыг нарийвчлан тодорхойлж, үлдэгдлийг бууруулах талаар эрх бүхий байгууллагуудтай хамтарч ажиллах, найдвартай авлагын асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.9. Зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Д.АРИУНБОЛД





Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн  
126 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах агаажэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх агаажэмжээ
1	Тушаал, шийдвэргүй зарцуулсан агаажэмжээ	Захирал Н.Чимэддорж Ерөнхий ня-бо Ц.Ууганбаяр	29,321.5	Нягтлан бодох бүртгэлийн хууль, Сангиин сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны жуурмыг мөрдэж ажиллах,
	Захиалгын хуудасгүй бэлтгэсэн бараа материал	Захирал Н.Чимэддорж Ерөнхий ня-бо Ц.Ууганбаяр	40,000.0	
2	Үргүй зардал	Захирал Н.Чимэддорж Ерөнхий ня-бо Ц.Ууганбаяр	16,387.0	Монгол Улсын төсвийн тухай хууль, Компанийн тухай хуулийг мөрдэж ажиллах
3	Шууд гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАУХА тухай хуульд заасан материалыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй	Захирал Н.Чимэддорж Ерөнхий ня-бо Ц.Ууганбаяр	720,009.0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.3-д заасныг мөрдэж ажиллах,
4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.1, 8.4-г зөрчсөн худалдан авалт хийсэн	Захирал Н.Чимэддорж Ерөнхий ня-бо Ц.Ууганбаяр	157,811.9	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдэж ажиллах
	Дүн		963,529.4	